

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

IV

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Ответственный редактор:	Академик С.Чулуун
Научные редакторы:	доктор филол. наук И.В.Кульганек Ph.D Н.Хишигт
Редакторы, составители:	Ph.D Б.Нацагдорж канд. филол. наук. Н.С.Яхонтова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г. Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.
© Институт восточных рукописей РАН, 2021 г.
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОЛОН УЛСЫН
МОНГОЛ СУДЛАЛЫН
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун

Эрдэм шинжилгээний редактор:

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

Редактор, эмхэтгэгчид:

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN
ACADEMY OF
SCIENCES
Institute of History
and Ethnology



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

IV

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Managing Editor:	Academician S.Chuluun
Scientific Editors:	Dr.Sc. (Philology) I.V.Kulganek Ph.D (History) N.Khishigt
Editor, compiler:	Ph.D (History) B.Natsagdorj Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova

Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections. Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021
© International Association for Mongol Studies, 2021

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

Өмнөтгөл (С.Чулуун)	9
<i>Г.Ариунтуяа</i>	
Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний хувийн хөмрөг	11
<i>Д.Баярсайхан</i>	
Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм	23
<i>Ts.P.Vanchikova</i>	
Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and Problems of its Research and Conservation	35
<i>Ж.Гэрэлбадрах</i>	
Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга	43
<i>Л.С.Дампилова</i>	
Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой в ЦВРК ИМБТ СО РАН	57
<i>Ж.Долгорсүрэн</i>	
Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун: хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд	65
<i>Г.А.Дыргеева</i>	
Традиционная письменная культура Бурят: социоллингвистический аспект	73
<i>Г.А.Гребенищикова</i>	
Монголия в планах Военного и Морского ведомств России в 1903-1913 годах	84
<i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>	
«История монголов» О.М.Ковалевского: первое прочтение	98
<i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>	
К вопросу о деятельности Советника при Монгольском правительстве П.А.Витте	107
<i>С.Мөнхсайхан</i>	
Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ	121
<i>Б.Нацагдорж</i>	
Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай тодруулах нь	136

Д.А.Носов

Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках
по Монголии 1923—1925 гг. 149

К.В.Орлова

Документальное наследие калмыков: письма калмыцких ханов 160

Р.Ю.Почекаев

Суд и процесс в монгольских «Хождениях в ад» 167

Г.Сэр-Од

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх
Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг 176

М.В.Федорова

Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв.
в собрании Российского этнографического музея, как источник
для изучения традиционной культуры монголов 186

Ц.Цэрэндорж

XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд
холбогдох мэдээ баримтаас 204

Д.Энхцэцэг

Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай 219

Ц.Энхчимэг

“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн
чухал сурвалж болох нь 240

Н.С.Яхонтова

Аспиранты из Монголии в Академии наук 250

Сведения об авторах 268

Зохиогчдын танилцуулга 272

С.Мөнхсайхан

УЛАМЖЛАЛТ МОНГОЛ ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮДИЙН ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ ХИЙГЭЭД СУРВАЛЖ БИЧГИЙН ҮНЭ ЦЭНЭ

DOI 10.25882/vpb1-t128

Бидний үед өвлөгдөн ирсэн уламжлалт хэл зүйн бичгүүд нь эдүгээ монгол бичиг үсгийн түүх соёлын үнэт өв болон үлджээ. Иймээс эдгээр бичгүүдийг хэвлэн нийтлэх, судлан сурталчлах ажлыг монголч эрдэмтэд өөрсдийн хүчин чармайлтаар тасралтгүй хийсээр ирсэн байдаг. Зохиогч энэхүү ажилд өөрийн хувь нэмрийг оруулах зорилгоор XVIII-XX зууны үед хэвлэгдсэн есөн хэл зүйн бичгийг танилцуулж байна. Эдгээр сурвалж бичгүүдэд уйгуржин монгол бичгийн зөв бичих ёс хийгээд монгол хэлний авиа зүй, үг зүй, үсэг зүй, хэл зүйн харьцааг нарийн тодорхойлон заасан байдаг бөгөөд энэхүү үзэл баримтлалыг одоог хүртэл мөрдсөөр байгаа билээ.

Түлхүүр үг: Монгол хэл шинжлэл, хэл зүйн бичиг, сурвалж бичиг, бар хэвлэл, соёлын өв

Munkhsaikhan Serjeegiin

THE LINGUISTIC SIGNIFICANCE OF THE TRADITIONAL MONGOLIAN GRAMMARS AND THEIR SOURCE VALUE

The traditional grammars inherited in our time have become a historical and cultural valuable heritage of script. Therefore, Mongol scholars have been persistently studying and publicized these grammars by their efforts. The author presents nine grammars that were published during the XVIII-XX centuries to contribute. There are details of the correct spellings of the uyghuro-Mongol script, phonology, morphology, and linguistic relation of the Mongolian language in these source documents. Additionally, these concepts are followed still today.

Keywords: Mongolian linguistics, grammar, source document, bar edition, cultural heritage.


Монгол хэлний анхны хэл зүйн бичиг нь монголчуудын бичиг үсгийн түүхтэй буюу уйгаржин бичгийг авч хэрэглэсэн цаг хугацаатай холбогддог. Учир нь монголчууд түүхэндээ 10 орчим бичиг үсэг хэрэглэж ирсэн бөгөөд ингэж бичиг үсгээ өөрчлөн “шинэчлэх” бүртээ дагалдах хэл зүйн бичгийг зохиож ирсэн уламжлал нь үүнийг гэрчилнэ. Тэгвэл монголчууд хамгийн анх хэл, соёл ойролцоо уйгар улсаас бичгийг нь авч хэрэглэсэн бөгөөд ингэхдээ уйгур улсын ид мандаж байсан VIII зууны үест үсгийг нь хэрэглэж, монгол үгээ тэмдэглэж байсан гэж судлаачид үздэг. Иймд чухам энэ үед монгол үсгийн цагаан толгой хийгээд түүнийг зөв холбон бичих хэл зүйн үндэс тавигдсан гэж үзэж болно. Гэхдээ энэ үеийн монгол бичгийн цагаан толгой хийгээд хэл зүй нь зөвхөн тодорхой нэг овог аймгийн хэл аялгууны онцлогийг хадгалсан байх магадлалтай ба хожим XIII зууны үест их эзэн Чингис хаан олон монгол аймгуудыг нэгтгэн нэг төрийн дор нэгдмэл хууль цаазаар Их Монгол улсыг удирдах болсноор олон нутгийн аялгууны онцлогийг хадгалсан нэгдсэн бичгийн хэлтэй болох шаардлага гарсан нь тодорхой юм. Бидэнд байгаа баримтаар бол, Юань улсын үеэс уйгар, төвд эрдэмтдийн удирдлагаар буддын шашны олон ном зохиолыг орчуулах ажлыг идэвхтэй хийж эхэлснээр монгол бичгийн хэлний дүрмийг жигдлэн тогтоох шаардлага гарсан байна. Өөрөөр хэлбэл, энэ үед энэтхэг, төвдөөс олон тооны ном зохиолыг орчуулсан нь тусгайлан орчуулгын зохиолын хэл үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд энэхүү орчуулгын зохиолын хэл нь эргээд утга зохиолын хэлнийхээ хөгжилтөд онцгой сайнаар нөлөөлж, чухам энэ үеэс монгол утга зохиолын хэл нь ярианы хэлнээсээ ялгамжаатай болж иржээ.

Хамгийн анхны хэл зүйн дурсгалт бичиг нь Сажа бандида Гунгаажалцан (1188-1251)-ы зохиосон “**Зүрхний толт**” хэмээх хэл зүйн бичиг юм. Энэ нь монгол хэлний зүйн судалгаа энэ үеэс эхэлсэн гэсэн үг биш бөгөөд гагцхүү түүхэнд гарах мэдээ баримтаар бидэнд уламжлан ирсэн хамгийн анхны хэл зүйн бичиг болно. Түүнийг зохиосон тухай баримт гагцхүү Агваандандар лхаарамбын “*Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг*” хэмээх номд тэмдэглэсэнээс бид мэддэг. Одоо мэдэгдэж байгаа баримтаас дурдвал, Гунгаажалцан монгол бичгийн хэлний авианы бүтцийг судалж 44 үсэгтэйгээр хэл зүйгээ зохиожээ. Мөн монгол хэлний үндсэн авиануудыг эгшиг гийгүүлэгч гэж хоёр хуваагаад цааш нь эгшиг үсгээ эр, эм, эрс гэж гурав хуваасан байна. Хэдийгээр Гунгаажалцаны энэхүү хэл зүйн бичгийг төвд хэлний хэл зүйд шүтсэн гэж үздэг боловч хожмын үеийн олон хэл зүйн бичгийн

үндэс болсноороо, түүнчлэн монгол хэлний эгшиг авианы байрлалын чухал хуулийг нээсэн гавьяатай юм.

Үүний дараа Хайсан хүлэг хааны (1308-1311) үед Чойжи-Одсэр бандида Сажа бандида Гунгаажалцаны зохиосон “Зүрхэн толт”-ыг нэмэн дэлгэрүүлж “**Зүрхний толтын тайлбар**” хэмээх хэл зүйн бичгийг зохиожээ. Гэвч энэхүү хэл зүйн бичиг нь бас л бидний үед бүрэн бүтнээрээ уламжлан ирсэнгүй, хожим уг хэл зүйг дэлгэрүүлэн тайлбарласан “Огторгуйн маань”, “Монгол үсгийн толтоос өчүүхэн заавар”, “Монгол үсгийн ялгал ба бие махбодын өчүүхэн товчнууд” зэрэг зохиолуудаас товч мэдэж болдог. Чойжи-Одсэр хэл зүйгээ 123 үе үсэгтэй зохиогоод эгшиг үсгээ эр, эм, эрс гэж хуваасан нь Гунгаажалцаны санааг уламжлан авсан хэрэг бөгөөд ингэхдээ нэг өргөлтөд үгийн бүрэлдэхүүнд орсон авианы бие биедээ нөлөөлөх байдал дээр үндэслэсэн эгшиг авианы фонемын байрлалын хуулийг өөрийн хэл зүйдээ бүрэн хэрэгжүүлсэн юм. Түүний энэхүү бүтээл нь монгол үсэг зүй, бичлэгийн дүрэм, авианы бүтэц, үг хувьсах ёс зэрэг хэл зүйн үндсэн асуудлыг хамарснаараа монгол бичгийн хэлийг улам боловсронгуй болгоход үлэмж түлхэц болсон төдийгүй XIV зууны монгол хэл шинжлэлийг цоо шинэ төвшинд хүргэсэн юм.

Энэхүү хоёр хэл зүйн бичиг нь хэдийгээр уг эхээрээ уламжлан ирээгүй ч тэдгээр бүтээлийн гол санаа нь хожмын үеийн зохиолуудад уламжлагдсан ирсэн байдаг ба тэдгээрийн нэг нь XVIII зууны үе (1727 он)-д Данзандагвын зохиосон “Зүрхэн толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маань хэмээх оршив” хэмээх зохиол болно.



Уг зохиол олон удаа модон бараар хэвлэгдсэнээс бидэнд одоогоор 3 бар олдоод байна.

1. 8см × 42см хэмжээтэй барын, хайрцагтай 17 хуудас Бээжинд хэвлэгдсэн нэг бар,
2. Ага дацанд хэвлэгдсэн 26 хуудастай 7см × 40см хэмжээтэй хайрцагтай бас нэг барын 6 ном,
3. 24 хуудастай 6см × 38см хэмжээтэй барын хайрцаг бүхий нэгэн бар

Үүнээс гадна Үндэсний номын санд бийрийн бичмэл нэг эх байна. Бас П.Балданжапов “**Jirüken-ü tolta-yin tayilburi** монгольское грамматическое сочинение XVIII века” нэртэйгээр ОХУ-ын Улаан-Үд хотод буриад модон барын эхийг нь судалгааны хамт хэвлүүлсэн юм. Мөн БНХАУ-д Монгол тулгар бичгийн цувралаар 2015 онд хэвлэгдсэн “**Монгол хэлний судлалын дурсгалт бичгүүд, нэгдүгээр эмхэтгэл**”-д Бээжингийн модон бар тэргүүтэй модон барын 3, бийрийн бичмэл 2, хорголжин барын 3 бүгд найман төрлийн эхийг товч тайлбартай хэвлүүлсэн байна.

Монгол хэл шинжлэлийн түүхэнд онцгой байрыг эзэлдэг энэхүү “**Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маань**” хэмээх зохиолыг Манж Чин улсын Найралт төв хааны үед (1723-1735 он) Алшаагийн эрдэмтэн рабжамба Данзандагва 1727 онд зохиожээ. Бидний үед уламжлан хүрч ирсэн эртний монгол хэл зүйн бүтээлүүдийн дотроос хамгийн эртнийх нь бөгөөд монгол хэл бичгийн нэлээд олон чухал асуудлыг хамран дэлгэрэнгүй тайлбарласнаараа дараа дараагийн эрдэмтдийн зохиосон хэл зүйн бүтээлүүдийн үндэс суурь болсоор ирсэн юм. Ийм учраас монгол хэл бичгийн судалгааны бүтээлүүдэд байнга дурдагддаг нэлээд сайн судлагдсан зохиол юм.

Зүрхэн толтын тайлбар зохиол нь Чойжи-Одсэрийн бичсэн шүлгээр эхлэх бөгөөд гурван үндсэн бүлэгтэй юм. Үүнд, 1. Монгол бичиг үүсэж хөгжсөн түүх, 2. Үсгийн ялгал, 3. Махбодийн ялгал эдгээр бөгөөд энэ үндсэн том бүлгүүд нь Чойжи-Одсэрийн зохиосон зүрхний толтод байжээ. “**Алин цагт гарсан уг**” хэмээх эхний бүлэгтээ монголд шашин дэлгэрсэн, бичиг үсэг үүсэн гарсан, хэл зүйн бичиг зохиосон түүхийг хураангуйлан өгүүлжээ. “**Үсгийн ялгал**” хэмээх хоёрдугаар бүлэгтээ монгол бичгийн үсгийн бүрэлдэхүүн, ангилал, эгшиг гийгүүлэгч үсгийн байрлал, нэрийн тийн ялгал зэрэг асуудлыг голлон өгүүлжээ. Мөн дэвсгэрлэх үсгийг чанга, хөндий, саармаг хэмээн ангилан тодорхойлжээ.


Түүнчлэн “Үсгийн ялгал” хэмээх хоёрдугаар бүлэгт нэрийн тийн ялгалын тухай бас дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Данзандагва монгол хэлний нэрийн тийн ялгалыг дуудах тийн ялгалыг оруулан 8 зүйл болгон ангилжээ. Данзандагва **“Махбодын ялгал”** гэсэн гуравдугаар бүлэгтээ монгол хэлний эгшиг гийгүүлэгч авиаг энэтхэг, хятадын ёсоор огторгуй, хий, гал, ус, шороо махбод гэж ангилаад тэдгээрийн хэлэгдэх байдлыг өгүүлэх эрхтний үйл ажиллагаатай холбон тайлбарлажээ. XVIII зууны нэрт эрдэмтэн Рабжамба Данзандагвын зохиосон уг хэл зүйн бичиг нь өнөөгийн бидний үед уламжлан ирсэн монгол хэл шинжлэлийн бүтээлүүд дотроос Чойжи-Одсэрийн зохиосон “Зүрхэн толт”-ыг тайлбарлан дэлгэрүүлсэн хамгийн эртний, хамгийн дэлгэрэнгүй тайлбар гэдгээрээ онцгой ач холбогдолтой юм.

Монгол уламжлалт хэл зүйн энэхүү алдартай бүтээлийг Т.Пагва, Б.Ринчен, Л.Мишиг, А.Лувсандэндэв, Ш.Лувсанвандан, Д.Төмөртоого, Ж.Төмөрцэрэн, түүнчлэн германы эрдэмтэн Таубе, Буриадын эрдэмтэн П.Б.Балданжапов, Өвөрмонголын эрдэмтэн Ө.Мандах, Насан-Урт нар судалжээ. Мөн өмнө дурдсан Сажа бандида Гунгаажалцан, Чойжи-Одсэр бандида нарын хэл зүйн бичгүүдийн талаарх мэдээ, монгол хэл шинжлэл, бичиг үсгийн түүхийг бидэнд уламжлан ирсэн хамгийн үнэ цэнтэй сурвалж бичиг юм.

2. Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээх оршив. Энэхүү хэл зүйн бичгийг зохиогч Агваандандар (1759-1842) нь Төвдийн Лхас хотод очиж “рабжамба” хэмээх номын дээд цол авсан Алашагийн зүүн хийдийн лам байжээ. “Хэлний чимэг”-ийн төгсгөлийн үгээс үзвэл энэ зохиолыг хэдэн онд зохиосон нь тодорхойгүй байгаа боловч 2в талд *“ер монгол үсгийг хэн хүн ямар газар аль цагт зохиосон хэмээвээс Өөлдийн хан Гооданы үед Сажа бандида Гунгаажалцантан Лан жоу хотод 4-р равжунгийн харагчин туулай жилд зохиосон буй. Түүнээс одоо Төр гэрэлтийн 8-р он шар хулгана хүртэл таван зуун наян таван он болжээ”* гэж буйгаас үндэслэн энэ зохиолыг Агваандандар 1828 онд зохиосон гэж үзэж байна.

“Хэлний чимэг” хэмээх энэ бүтээлийн тухай академич Б.Ринчен гуай *“Улсын номын санд буй бичмэл дэвтэр бол Алашаа бичээчийн бийрээр бичсэн ном”, “Орос цааснаа барласан 10 хуудас ном. Агын Дашилхүндүблингийн модон бар. Номын санд Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайд Онход овогт Жамьян гуай 1918 онд олж*

авчирсан”¹, “Долоон хуудас өвөрлөгч бар. Болгосон нангиад цааснаа барлажээ” хэмээн гурван номын тухай өгүүлжээ. Эдгээрээс 7 хуудастай Бээжин модон барынх нь өнөөдөр Үндэсний номын санд хадгалагдаж байна. П.Балданжапов “Kelen-U cimeg” монгольское грамматическое сочинение XIX века”² нэртэйгээр ОХУ-ын Улаан-Үд хотод буриад модон барын эхийг нь судалгааны хамт хэвлүүлсэн юм. Бас БНХАУ-д хэвлэгдсэн Монгол тулгар бичгийн цуврал эмхэтгэлийн “Монгол хэлний судлалын дурсгалт бичгүүд, нэгдүгээр эмхэтгэл”-д Бээжингийн модон бар тэргүүтэй 2 модон бар, 2 хорголжин бар, бийрийн бичмэл бүгд 6 эхийг гэрэл зургаар хэвлэжээ.



Бидний танилцуулж буй эх бол “Маха саду-а нэрт тойн нэгэн бээр мандсан гал гахай жил (1887 он) хэв дор сийлгэвэй” гэсэн төгсгөлийн үгтэй 10 хуудас 6,5см × 49см хэмжээтэй барын хайрцаг бүхий модон бар юм. Энэ нь халх монгол хэлбэрийн үсэгтэй, га, гэ үсэг нь цэгтэй, муутуу


¹ Б.Ринчен “Монгол бичгийн хэлний зүй” (тэргүүн дэвтэр) Удиртгал, УБ. 1964, 83-р тал.

² П.Балданжапов “Kelen-ü cimeg монгольское грамматическое сочинение XIX века” М., 1962.

цааснаа дарсан хувилбар болно. Уг зохиол нь авианы байрлалын хуулийг нарийвчлан тогтоосон талаараа монгол хэл шинжлэлийн түүхэнд чухал байр эзэлнэ.

Уг бүтээл нь модон бар, хорголжин барын хэвлэл болон хулсан үзгийн, бийрийн бичмэл хэлбэртэйгээр монгол нутагт ихээхэн тархаж гэрийн сургуулиудад өргөн хэрэглэгддэг байсан бөгөөд монгол сурвалж бичиг ном хэвлэлийн түүхийг өгүүлж чадахуйц үнэ цэнэтэй бүтээл болно.

3. Монгол үсгийн ялгалыг үзүүлэгч тодорхой толь. XIX зууны монгол хэл шинжлэлийн түүхэнд чухал байрыг эзлэх энэхүү бүтээлийг харьцангуй бага судалсан ба уг барын эх нь ч ховор байдаг бололтой. Энэхүү хэл зүйн бүтээлийг буриадын нэрт эрдэмтэн Сумадирадна буюу Лувсанринчин XV жарны хар усан луу жил буюу 1892 онд зохиожээ. Сумадирадна зохиолынхоо эхэнд монгол үсгийн цагаан толгойг дан эгшиг гийгүүлэгч хийгээд үе үсгээр ялган жагсааж эгшгийг эр, эм, эрс хэмээн ангилаад, авиа тус бүрийн онцлогийг тодорхой жишээгээр үзүүлжээ. Тухайлбал, эгшиг ба гийгүүлэгч үсгийн эхэн, дунд, доор гурван газар орох үлгэрийг 46 талд хүснэгтээр үзүүлсэн байна. Цааш нь дэвсгэр үсгүүд ба тэдгээрийн дараа шууд залган ордог “амь залгагч” орхицууд болон бусад нөхцөл дагавруудыг хэрхэн бичиж яаж дуудах тухай дэлгэрэнгүй тайлбарласан байна. Мөн нэрийн үндэс болон тийн ялгалын нөхцлийн талаар хүснэгтээр үзүүлжээ (22а хуудас).




Үүнээс гадна уг зохиолд нэрийн тийн ялгалын тухай асуудал ихээхэн чухал байрыг эзэлж байна. Тухайлбал, утгын мөн чанарын төдийг үзүүлэх анхны тийн ялгал, хоёрдугаар үйлсийг үзүүлсэн тийн ялгал, гуравдугаар үйлдэгч тийн ялгал, дөрөвдүгээр өгөгч тийн ялгал, тавдугаар тийн ялгал нь гарах угийг үзүүлсэн, зургадугаар барилдах орон барилдагдахуун хоёрын харьцаа, долдугаар орныг үзүүлсэн тийн ялгал, наймдугаар дуудахын тийн ялгал хэмээн найман тийн ялгал байна гээд зохих жишээ гарган тайлбарласан байдаг. “Тодорхой толь” хэмээх уг зохиолд монгол бичгийн хэлний залгавар морфемуудын хэл зүйн харьцааны үүрэг ба тэдгээрийн илэрхийлэх утгыг сайтар ажиглан, зохих ангилал хийсэн нь өмнөх хэл зүйчдийн бүтээлд огт байгаагүй сонирхолтой шинэ ажиглалт болсон төдийгүй монгол бичгийн хэлний нөхцөл дагаврын ангилал, нэрийн тийн ялгалын хэлзүйн харьцаа хийгээд утгын гол ялгааг нарийвчлан тогтоосноороо XIX зууны монгол хэл шинжлэлийн онолын төвшинг зохих хэмжээгээр урагш ахиулсан чухал ач холбогдолтой бүтээл болсон юм.

Эдүгээ уг сурвалж бичиг нь олдоход нэн ховор болсон бөгөөд бид академич Д.Төмөртоогогийн гэрийн номын санд хадгалагдаж байгаа эхийн гэрэл зургийг хэвлүүлж олны хүртээл болгосон билээ.

4. Блама өгүүлэхүйн арслан манзушири эгшигт эх дор мөргөж монголын зуун хорин гурван цагаан толгой үсгийг туурвисан оюун билгийн соёрхол хэмээгч оршив. Уг номын зохиогдсон оныг төгсгөлийнх үгэнд гарах “Эдүгээ Бүринт засагчийн гуравдугаар он, модон хулгана жилд... (шадарт явах Халхын да Илдэн ван хөгшин Тогтохтөр бээр Гиан чэн мэн³ дор явах туслагч гүн Бавуудорж хөвүүн эхлэн хошууны олон тайж ардын хөвүүд гурван зуун илүү дор монгол үсэг заалган, Боди мөрийн зэргийг хэлэлцүүлж бүхий үед ... Огторгуйн маанийг олж гол болгож ... Алашаа монлам рабжамба Агваандандарын зохиосон үгнүүдээс хэдийг авч бага сага дутагдсаныг өвгөн би мэргэдээс сонссоноо нэмж эвлүүлэн Бээжин газар одох замд товч төдий найруулсан) мэдээнээс үндэслэн 1864 он гэж үздэг.

³ 乾清门 qián qīng mén—Яамны нэр.




Уг зохиол нь Данзандагва, Агваандандар нарын хэл зүйн бичгүүдэд тулгуурлан зохиогдсон байна. Тогтохтөр буюу То ван зохиолынхоо эхэнд монгол үсгийн цагаан толгой, галиг үсгүүдийн зөв бичих дүрэм журмын талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Мөн монгол үсгийг анх зохиосон, хожим түүнийг нэмэн зассан тухай ч тодорхой өгүүлсэн байна. Тогтохтөр энэхүү номдоо монгол хэлний авиаг энэтхэгийн ёсоор махбод болгон ангилж, авиа тус бүрийн хэлэгдэх байдлыг тодорхойлсон нь Данзандагвын “Огторгуйн маань”-ийн махбодын ангилалтай үндсэндээ таарч байна. Зохиолын 8в талд үсгийн махбодыг хүснэгтээр үзүүлж хоолойн хэлний үзүүрийн, уруулын хэмээн дуун ухааны үүднээс ялгажээ. Зохиолын төгсгөлд монголд шашин дэлгэрсэн түүхээс товч дурдсан байдаг.

Орос цаасан дээр модон бараар барласан 14 хуудас бүхий ном болно. Монгол улсын үндэсний номын санд нэг хувь байгаа ба түүнийг “Монгол улсын 19 дүгээр онд Хан Хэнтий уулын аймгаас сурвалжлан захиж ирүүлсэн” хэмээн академич Б.Ринчен бичжээ.

5. Эгшиг үсэг хийгээд гийгүүлэгч үсгүүд оршив. XVI-XVII зууны үеийн монгол бичгийн хэлэнд санскрит, төвд зэрэг харь хэлний үг хэллэг, ухагдахуун, нэр томьёо олноор нэвтрэн орсон нь тэр бүхнийг нарийн зөв галиглан бичих шаардлагыг буй болгожээ. Энэ бүхнийг зөвхөн монгол хэлний үг тэмдэглэхэд зориулан зохиосон 123 үсэг

хангаж чадахгүй болсон байна. Иймд Али гали буюу харь хэлний үгийг тэмдэглэх галиг үсгийг 1587 онд Харчины Аюуш гүүш үсэг зохиосон бөгөөд хожим XVIII зууны дундуур үзэмчин гүн Гомбожав түүнийг цааш нь улам боловсронгуй болгон нэмж засан хэвлүүлжээ.




Үзэмчин гүн Гомбожавын 1723-1742 оны хооронд зохиосон энэхүү бүтээл нь өмнөх галиг үсийн бүтээлүүдийг улам сайжруулан Энэтхэгийн ланз үсэг болон төвд үсгийг монгол үсгээр хэрхэн галиглан бичих дүрэм журмыг тогтоосноороо монгол хэлний галиг үсгийн тогтолцоог боловсронгуй болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Монголын үндэсний номын санд энэ ном төгсгөлийн үгтэй, үггүй гэсэн барын хоёр хувилбар байна. Буриад модон барынх нь төгсгөлийн үггүй ба харин нангиад болгомол цаасан дээр хэвлэсэн Бээжин барын эх нь төгсгөлийн үгтэй юм. Б.Ринчен “Орос цааснаа барласан 8 хуудас ном. Энэтхэгийн ланза, төвд, монгол гурван үсэг хадмал ном. Хаанахын бар болохыг оноон эс чадав” гээд Агын Дашилхүндүблингийн бар байж болохыг дурджээ⁴. Уг хоёр бар нь зөвхөн төгсгөлийн үгтэй, үггүйгээрээ ялгагдаж байгаа бөгөөд энэхүү номдүү төгсгөлийн үг бүхий 7 хуудас Бээжин барын номыг хэвлэж байна. Судрын хэмжээ нь 10,5 × 51,5 см.

6. Дээд шашин эрдэнэ бээр монгол орныг түгээгүүлсэн угийг үзүүлсэн яруу хэлний хүрхрэл нэрт оршив. XIX зууны монголын нэрт эрдэмтэн Лувсанринчин 1821 онд өнөөгийн ОХУ-ын Буриад нутагт төржээ. Уг зохиолыг судалсан эрдэм шинжилгээний бүтээл ховор ажээ.

⁴ “Монгол хэлний зүй” (тэргүүн дэвтэр) Удиртгал УБ. 1964, 104-р тал.

Академич Д.Төмөртоогоо, судлаач Г.Энхтуул нарын өөрсдийн бичсэн бүтээлдээ зохиолын агуулгыг тодорхойлон бичсэн⁵ байдаг. Монгол оронд бурхны шашин дэлгэрсэн ба бичиг үсгийн ухаан дэлгэрсэн тухай өгүүлсэн энэхүү зохиол нь агуулгын хувьд үндсэн хоёр хэсгээс бүтнэ. **Нэгдүгээр хэсэгтээ**, Мөнх хааны үед шашин төр хосолсон, Хубилай хааны үед Сажа бандида Гунгаажалцан монгол үсэг зохиосон, Чойжи-Одсэр сүүлт үсэг тэргүүтнийг нэмж монгол хэлээр ном орчуулсан ... гэх мэтээр өгүүлсэн бол **Хоёрдугаар хэсэгтээ**, төвд үсгийг зохион дэлгэрүүлсэн, монгол хэлээр ном орчуулсан түүх, монгол хэлээр ном дэлгэрүүлсэн их хаадын нэр, молом равжамба Данзандагва зүрхний толтыг зохиосон ... түүхийг өгүүлжээ. Уг ном нь монгол төвд түүхийн олон ном судар ашиглан эмхэтгэж бичсэн унших бичгийн шинж чанартай тул монголын түүх болон монгол хэл бичгийн холбогдолтой эрдэм шинжилгээний олон мэдээ баримтыг агуулсан байна. Түүнчлэн монгол үсэг бичгийн түүх, хэл зүйчдийн бүтээлээс гадна монгол түүхийн талаар олон үнэтэй баримт агуулсан зохиол юм.



7. Монгол үсгийн ёсыг тодорхойлон гаргасан алтан толь хэмээгдэх оршив. Шилийн голын Чуулганы Авгын баруун этгээд газрын хошууны захирагч занги Лхамсүрэн 1903 онд бичиж хэвлүүлсэн энэ номыг муутуу цаасан дээр модон бараар хар бэх хэрэглэн барлаж, дэвтэрлэн үдсэн байна. Номын хэмжээ 16см × 28см, 27 хуудастай. Хуудасны

⁵ Г.Энхтуул “Тодорхой толийг зохиосон Сумадираднаа (1821-1907)-гийн дуун ухааны бүтээлийн товч” МУИС Монгол хэл соёлын сургуулийн “Монгол судлал” ЭШБ. УБ. 2007. Боть ХҮП (285).

дугаарыг хятад үсгээр хамар дээр нь тавьсан байна. Энэ бүтээлийн тухай судалгааг дурдвал, БНХАУ-д хэвлэгдсэн “Монгол хэлний судлалын дурсгалт бичгүүд” номд 3 зүйлийн барыг гэрэл зургаар хэвлэжээ. Академич Б.Ринчен “Монгол бичгийн хэлний зүй” номдоо “Өвөрлөгч модон барын 26 хуудас ном. Үсэг нь бийрийн бичээчийн үсэг. Шилийн голын Чуулганы Авгын баруун этгээд засгийн хошууны захирагч занги Лхамсүрэн Бадаргуулт төрийн хорин есдүгээр оны харагчин туулай жил (аргын 1903 он) эхэн сард хэв дор сийлжээ”⁶ гэсэн бидний номдоо оруулсан эх болно. Түүнчлэн Үндэсний төв номын санд хорголжин барын бас нэгэн эх байна.




Лхамсүрэн захирагч энэ номынхоо эхэнд өмнөх хэл зүйчдийн нэгэн адил монгол монгол үсгийг анх их бандида Гунгаажалцан үүсгэн зохиож хожим Данзандагва “Зүрхэн толтын тайлбар огторгуйн маань” хэмээх судрыг зохиосныг гол болгон “Хэлний чимэг” зэрэг бусад олон бичиг зохиолыг үзэж нэмэх зүйлүүдийг нь нэмж мэдэхүйеэ хялбар болгон зохиосноо өгүүлсэн байна. Цааш нь хэлний авиаг эгшиг, гийгүүлэгч хэмээн ангилж улмаар эгшгийн байрын талаар “нэгэн үгнээ дуудах аялгуу чанга болбоос цөм чанга, хөндий болвоос цөм хөндий тул үсэг залган бичихэд ер эр эм хоёр үсгийг нэгэн үгэнд нийлүүлэн бичиж үл болно” гэсэн байна. Зохиогч мөн энд өмнөх үеийнхээ эр эмээс шалтгаалан дүрс нь өөрчлөгддөг -luᠢa/-lüge, -dayan/-degen, -nuᠢud/-nügüd зэрэг

⁶ Б.Ринчен “Монгол бичгийн хэлний зүй” (тэргүүн дэвтэр) Удиртгал” УБ. 1964, 91-92-р тал.

нөхцөл дагавруудыг “бусдын эрхэт”, дүрс нь өөрчлөгддөггүй abasu, atala, бүлүге зэргийг “өөрийн эрхэт” хэмээн нэрлэсэн байна. Ийнхүү энэ номд дэвсгэр үсгүүдийн байрыг гаргаж, эгшиг үсгийн үүргийг нарийн тодорхойлсон ба бичихэд гардаг түгээмэл алдаануудыг нэг мөр болгон журамлахыг хичээсэн байна. Мөн бичлэгийн өвөрмөц уламжлал бүхий зарим үсгийн тухай дэлгэрэнгүй тайлбарлажээ. Лхамсүрэн зангийн зохиосон энэ ном монгол үсэг сурах зөв бичихэд их л хэрэгтэй байсан тул модон бараас гадна бичмэл хувиар их тархаж байжээ.



8. Монголын эгшиг ба гийгүүлэгч үсгүүд түүний дэсгэрлэхүй лүгээ сэлт оршив. 9см × 35,3см хэмжээтэй орос цаасан дээр хар бэх модон бараар хэвлэсэн 9 хуудас бүхий энэ номын зохиосон он нь тодорхойгүй бөгөөд төгсгөлийн үгэндээ “... хэмээх үүнийг сайн зарлигийн хур буулгагч хийдийн гэлэн Лувсанринчин нэрт эвлүүлэв” гэснээс зохиогч нь мэдэгдэж байна. Энэхүү номд монгол хэл зүйн олон асуудлыг хамруулан оруулсангүй, зөвхөн үгийн эхэн, дунд, адагт бичигдэх үсгийн хэлбэр, арван нэгэн дэвсгэр үсгийн чанга, хөндий хэлбэрийг хүснэгт жишээгээр жагсаан үзүүлжээ.



Лувсанринчин эгшиг, гийгүүлэгч үсгийн тухай бичихдээ дан эгшиг 7 (a, e, i, o, u, O, U), дан гийгүүлэгч 16 (n, b, G, q, m, l, r, s, d, t, y, c, j, w, p, S) гэж гийгүүлэгчийг амилуулалгүй дангаар нь жагсаан бичсэнээс гадна, амилуулсан гийгүүлэгчийг (гийгүүлэгч эгшиг хоёрыг) найруулсан

үсэг гэх мэтээр нэрлэсэн байна. Эгшиг гийгүүлэгч үсгийг үгийн эхэн, дунд, адагт бичих байдлыг хүснэгтээр үзүүлсэн байна. Тухайлбал, долоон эгшгийг дангаар нь дэс дараалан хүснэгтлээд эхэн, дунд, адагт орох хэлбэрийг жишээ үгээр үзүүлж, тухайн үсгийн өмнө дугуй тэмдэг тавьж заажээ.

9. Монголын арван найман үсэг, арван нэгэн дэвсгэр гурван орхиц лугаа сэлт оршив. Том сайхан үсгээр бичиж сийлсэн найман хуудас бүхий буриад модон барын ном болно. Монгол үсгийн дуудлагыг төвд үсгээр хадаж үзэхэд хялбар болгосон байна. Чухам хаана барласан тухай мэдээ үгүй. Энэ номд монгол үсгийн хажууд төвд үсгээр дуудлагыг нь давхар тэмдэглэж хадсан байна. Энэ цагаан 18 үсэг, 11 дэвсгэр үсгийн дунд, адагт орох байдлыг үзүүлснээр сурахад дөхөмтэй бөгөөд үсгийн зүйлээс “орхиц” гэж монгол үсэгт дээд үсгээс салангид бичдэг “ᠠ (a, e), ᠢ (i), ᠣ (u, ü)” гурвыг тийнхүү салангид бичдэгээр нь орхиц гэж нэрлэдэг учрыг тайлбарлажээ. Дэвсгэр үсэг гэдэг нь монгол үгнээ үеийн эцсийн гийгүүлэгч буюу битүү үеийн адгийн гийгүүлэгчийг нэрлэх ба монгол үсгийн зөв бичих дүрэмд тэр дэвсгэр үсэг нэн чухал тул цагаан толгойд түүнийг зааснаар зөв бичих гол зарчмын нэгтэй танилцуулдаг байжээ.



Монголчууд бичиг үсгийн арвин их өв соёлтой ард түмэн бөгөөд уламжлалт хэл зүйн бичгүүдийн төлөөлөл болгож дээрх сурвалжуудыг танилцуулав. Үүнээс гадна монгол хэл шинжлэлийн түүхэнд чухал байр эзэлдэг олон бүтээлүүд байдаг бөгөөд тухайлбал, XVIII зууны үеийн хэл зүйч Урад гүүш Билгийндалай (Шаравжамц)-н зохиосон *“Монгол үсгийн ялгал ба махбодын өчүүхэн товчнууд”*, *“Монгол үсгийн тольтоос өчүүхэн заавар”*, *“Монгол үсгийн хүртээл зүрхний тольт”*, *“Чойжи-Одсэрийн зохиосон монгол үсгийн зүрхний тольт Огторгуйн маань хэмээхээс махбодгүйгээр өчүүхэн хурааж бичсэн сургуулийн эх үсэг оршив”* зэрэг хэл зүйн бичгүүд, XIX зууны хэл зүйч Алшаагийн Зүүн хийдийн Буяныг үндэслэгч сүмийн Да лам Дагвашаравын зохиосон *“Монгол үсгийн утгыг чухал заасан дэлгэрэнгүй оюут”* (1853), Өвөрмонголын Хишигтэн хошууны ширээт тойн Дэлэгжунайн бичсэн *“Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь”* (XIX), XIX зууны хэл зүйч Цэцэн хан аймгийн Нанзаддоржийн зохиосон *“Монгол үсгийг төвд үсэгт шүтэж төвөг багатайяа мэдүүлэгч түлхүүр, харанхуйг арилгагч зул”*, мөн XIX зууны хэл зүйч Түмэдийн Галсангийн *“Монгол үсгийн арван хоёр цагаан толгой”* (1828), *“Монгол үсгийн бүгд тайлбар бичиг”* хэмээх хоёр хэл зүйн бичиг, Манжийн түгээмэл элбэгтийн үеийн түшмэл Сайшингаагийн зохиосон *“Урьд монгол бичгийн чухлыг заасан дөрвөн бичиг”* зэрэг олон зохиол бидний үед уламжлагдан иржээ. Гэвч эдгээр нь эдүгээ олдоход бэрх болсон тул сурвалжлан цуглуулж судлан нийтлэх, олон нийтийн хүртээл болгох ажил зайлшгүй хэрэгтэй байна.

XVIII-XX зууны эхэн үеийн уламжлалт хэл зүйн бичгүүд нь дорно дахины хэл шинжлэлийн сэтгэлгээний дэвшилтэт онолыг бүтээлчээр ашиглан монгол хэлнийхээ дотоод зүй тогтлыг олон талаас нь судалж авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэлзүйн харьцаа зэрэг үндсэн шинжүүдийг нээн олсноороо хэл шинжлэлийн чухал ач холбогдолтой төдийгүй энэхүү үзэл баримтлал нь орчин цагийн монгол хэлний авиа зүйн шинжлэх ухааны үндэс суурь нь болсон юм. Түүнчлэн тэдгээр нь монгол бар хэвлэл, гар бичмэлийн дахин давтагдашгүй соёлын өв бөгөөд монгол бичгийн хөгжил, монгол утга зохиолын хэлний хөгжил, монгол хэл шинжлэлийн түүх зэргийг бидэнд уламжлан авчирснаараа сурвалж бичгийн үнэ цэнэ нь тодорхойлогдож байна.